

ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУДЫН ХЭРЭГЖИЛТ

№	Зорилт	Арга хэмжээ	Суурь үзүүлэлт		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Зарцуулсан төсөв /сая төгрөг/	Гүйцэт гэлийн хувь	Үнэлгээ ний хувь	Дэлгэрэнгүй тайлбар /хэрэгжээгүй шалтгаан/	Санал дүгнэлт
			2010	2019 оны түвшин							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэг. Авто замын салбар											
1	Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн	Улаанбаатар-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто	104 км	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.	Хүн амын чөлөөтэй аялж, зорчихын	2016.07.17-нд хэрэгжиж дууссан.	49,558.76	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
2	төвүүдийг ойролцоох хилийн боомтуудтай	Мандалговь-Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто	173 км	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.	зэрэгцээ ачаа эргэлт, бизнесийн орчны боломж	2013.10.02-нд хэрэгжиж дууссан.	50,826.62	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
3	холбосон 5572км авто зам барих	Баянхонгор-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто зам	269 км	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4км, Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126 км замуудын барилгын ажил явагдаж байна.	бүрдэнэ. Мөн улс хооронд босоо тэнхлэгийн 5 гарцаар зорчино.	Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар эхэлсэн.	124,048.00 76.96 сая ам. доллар	88.60% 11.70%	30%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдэхгүй удааширсны улмаас төлөвлөгдсөн ажлууд оройтож эхэлсэн. Барилгын ажлуудыг гэрээгээр 2019 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	2020 оноос өмнө уг чиглэлийн авто замыг ашиглалтад бүрэн оруулах боломжтой гэж үзэж байна. Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126 км авто замын Концессын гэрээний асуудлыг яаралтай шийдвэрлэж барилгын ажлыг эхлүүлэх шаардлагатай байна. Тус замын концесс эзэмшигчээр "Эрчим хүчний барилга трест" ХХК шалгарсан, хэрэгжилтийг Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байна.
4		Алтай-Бургастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	319 км	Барилгын ажил хийгдээгүй		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. Мөн ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос Казахстан, Киргиз, Монгол, БНХАУ болон ОХУ-ыг хамруулан "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн зорилтуудын хэрэгжилтийн хүрээнд 2018 оноос эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төлөвлөж буй "Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцыг бэхжүүлж, Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030-д туссан хил дамнасан сорилт, бэрхшээлүүдийг шийдвэрлэх нь" төслийн хэлэлцүүлгийн үед энэ чиглэлийн авто замын техник, эдийн засгийн үзүүлэлтийн судалгааг хийхээр ЗТХЯ-аас санал хүргүүлсэн. Одоогоор албан ёсны хариу ирээгүй байна. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх саналтай байна. Мөн гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай гэж үзэж байна.
5		Алтай-Манхан чиглэлийн хатуу хучилттай авто зам	374 км	Манхан -Дарви чиглэлийн 100 км авто зам		2014.11.21-нд хэрэгжиж дууссан.	42,973.84	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
				Алтай-Дарви чиглэлийн 263 км авто замыг ВТ нөхцлөөр Концессоор барьсан.		2016.12.25-нд хэрэгжиж дууссан.	906.6 сая иен	100%		-	

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
6		Улиастай-Алтай чиглэлийн хатуу хучилттай авто зам	139 км	Зураг төсөл боловсруулагдсан, барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	347.50	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замыг 2018 оноос эхлүүлэхээр тусгагдсан бөгөөд 2017-2019 оны улсын төсвийг боловсруулах бүрд ЗТХЯ-наас уг авто замн хөрөнгийг шийдвэрлэх тухай санал өгсөн боловч тухай бүр дэмжигдээгүй хасагдсан болно. Иймд 2020 оны Улсын төсөвт тусгуулахаар дахин санал өгөх шаардлагатай байна.
7		Дашинчилэн-Булган чиглэлийн хатуу хучилттай авто зам	121 км	Булган-Хишиг-Өндөр чиглэлийн 22 км замын барилгын ажил явагдаж байна. 2019 онд үргэлжлэх 10 км замын ажил эхэлнэ.		Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар эхэлсэн.	4,922.30	Булган-Хишиг-Өндөр чиглэлийн 22 км замын барилгын ажил 90% тай явагдаж байна.	30%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдэхгүй удааширсны улмаас төлөвлөгдсөн ажлууд оройтож эхэлсэн. Булган-Хишиг-Өндөр чиглэлийн 22 км замын барилгын ажлыг 2019 онд, дараах 10 км замын ажлыг 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.	Хөрөнгө оруулалтын хэмжээ бага байгаагаас шалтгаалан жил бүр төсөвт тусган хэрэгжүүлж байгаа авто замын урт нь бага байна. Хэрвээ УИХ-аас энэ чиглэлийн авто замын барилгын ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг энэ хэвээр бага хэмжээнд баталсаар байвал төслийн хэрэгжилт удааширч 2022 оноос өмнө дуусгах боломж бүрдэхгүй. Иймд 2020 онд УИХ-аас хөрөнгийн хэмжээг уг замыг барьж дуусгахад хүрэлцэхүйц хэмжээгээр нэмэгдүүлж батлан барилгын ажлыг 2021 онд дуусгах шаардлагатай байна.
8		Тариалан-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто зам	171 км	Барилгын ажлыг "Эйч Кэй Би" ХХК 88 км, "Хотгор зам" ХХК 32км, "Их Монгол барилга" ХХК 25 км, "Пик девелопмент" ХХК 29.3 км замуудыг тус тус барьж 2014, 2015 онуудад улсын ашиглалтад оруулсан.		2014.10.16-нд хэрэгжиж дууссан.	86,384.95	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
9		Өгийнуур-Батцэнгэл-Их-Тамир чиглэлийн хатуу хучилттай авто зам	104 км	63 км авто замын барилгын ажил 2019 онд эхэлнэ.		Хэрэгжээгүй	280.80	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил 2018 онд эхлээгүй. 2019 онд эхлэлийн 63 км зам, Орхоны 220 у/м гүүрийг ашиглалтад оруулахаар төлөвлөөд байна.	ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замыг 2018 оноос эхлүүлэхээр тусгагдсан бөгөөд 2018 оны улсын төсөвт санал өгсөн боловч хасагдсан болно. Харин 2019 оны Улсын төсөвт энэ чиглэлийн авто замын барилгын ажлыг эхлүүлэхээр тусгасан тул барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөж байна. Зам барилгын ажлын үлдсэн хэсгийг бүрэн барьж дуусгах үлдэгдэл хөрөнгийг 2020 оны Улсын төсөвт тусгуулахаар санал өгөх шаардлагатай байгаа бөгөөд дэмжигдсэн тохиолдолд 2021 онд багтаан зам барилгын ажлыг дуусгах боломжтой болно.
10		Цахир-Тосонцэнгэл чиглэлийн хатуу хучилттай авто зам	101 км	Цахир-Тосонцэнгэл чиглэлийн авто замыг "Хурдны зам" ХХК барьж 2017 онд улсын ашиглалтад оруулсан.		Хэрэгжсэн	65,881.30	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
11		Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	181 км	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км замын барилгын ажил хийгдэж байна.		Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар эхэлсэн.	111,091.20	63%	70%	-	2020 оноос өмнө уг чиглэлийн авто замыг ашиглалтад бүрэн оруулах боломжтой гэж үзэж байна. Санхүүжилтээс шалтгаалан зогсонги байдалд ороод байгаа Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км замын барилгын ажлыг яаралтай үргэлжлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
12		Улиастай-Ховдын Мянгадын гүүр чиглэлийн авто зам.	430 км	Улиастай-Донойн хөндий чиглэлийн 29.4 км, Мянгадын гүүр-Дөргөн чиглэлийн 20 км авто замууд баригдсан. Бусад замын ажил эхлээгүй байна.		Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар хийгдсэн	18,688.80	11.40%	30%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас баригдаагүй үлдсэн авто замуудын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна. Улиастай-Дөрвөлжин чиглэлийн 113 км, Завхан аймаг Сархайрханаас Эрдэнэхайрхан чиглэлийн 160.3 км хатуу хучилттай замын нарийвчилсан зураг төслийг "ХЗТ Авто зам" ХХК, "Эн Би Си Си" ХХК-иуд 2013 онд тус тус боловсруулсан байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил хийгдээгүй. Мөн ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул үлдэгдэл 380 км авто замын 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Уг чиглэлийн авто замыг ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх саналтай байна. Мөн Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай гэж үзэж байна.
13		Ховд-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	190	Улаангом-Наранбулаг чиглэлийн 90 км авто зам баригдсан, Наранбулаг-Ховд чиглэлийн авто замын зураг төсөл боловсруулагдсан, зам барилгын ажил эхлээгүй байна.		Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар хийгдсэн	47,883.37	47%	30%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас баригдаагүй үлдсэн авто замуудын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна. Ховд-Улаангом чиглэлийн 163.3км хатуу хучилттай авто зам, 90 у/м төмөр бетон гүүрийн инженерийн нарийвчилсан зураг төслийг "Гео зураглал" ХХК 2012 онд боловсруулсан байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил хийгдээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замын барилгын ажлыг 2018 онд эхлүүлэхээр тусгагдсан тул бөгөөд 2018, 2019 оны улсын төсөвт санал өгсөн боловч хасагдсан болно. Иймд үлдэгдэл 100 км авто замын 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Уг чиглэлийн авто замыг МУЗГ-ын 2020 оны төсөвт тусган хэрэгжүүлэх саналтай байна. Мөн гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай гэж үзэж байна.
14		Завхан аймгийн Тосонцэнгэл сумын баруун талд орших 4 замын уулзвараас-Нөмрөг-Наранбулаг-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто зам	490 км	Улаангом-Наранбулаг-Хяргасын зүүн хаяа чиглэлийн 190 км, Хяргасын зүүн хаяа-Сонгино чиглэлийн 135км авто замаас 85 км авто зам, нийт 275км ашиглалтад орсон. Хяргасын зүүн хаяа-Сонгино чиглэлийн 50 км, Тосонцэнгэлийн 4 замын уулзвараас - Сонгино сум чиглэлийн 167км, нийт 215 км авто замын барилгын ажил явагдаж байна.		Барилгын ажил хэсэгчилсэн байдлаар хийгдсэн	93.3 тэрбум төгрөг, 86.5 сая ам.доллар, 660 сая юань	56.1	30%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдэхгүй удааширсны улмаас төлөвлөгдсөн ажлууд оройтож эхэлсэн. Тосонцэнгэлийн баруун талд орших 4 замын уулзвараас-Нөмрөг-Наранбулаг-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажил концессийн гэрээгээр хэрэгжиж байна.	2020 оноос өмнө уг чиглэлийн авто замыг ашиглалтад оруулах бүрэн боломжтой гэж үзэж байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
15		Шивээхүрэн-Баянхонгор чиглэлийн хатуу хучилттай авто зам	505 км	Барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. Мөн ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. чиглэлийн авто замыг ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх саналтай байна
16		Баянхонгор-Улиастай чиглэлийн хатуу хучилттай авто зам	470 км	Барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. Мөн ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. чиглэлийн авто замыг ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх саналтай байна
17		Нөмрөг-Цагаан толгой /Арц суурь/ чиглэлийн хатуу хучилттай авто зам	199 км	Барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Уг чиглэлийн авто замыг ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх саналтай байна
18		Өндөрхаан - Чойбалсан чиглэлийн хатуу хучилттай авто зам	87 км	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан. Энэ чиглэлд нийтдээ 238 зм авто зам шинээр баригдсан.		2015.09.23-нд хэрэгжиж дууссан.	136,867.32	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
19		Өндөрхаан-Мөнххаан-Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай авто зам	178 км	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.		2017.01.26-нд хэрэгжиж дууссан.	144,161.43	100%	100%	-	Барилгын ажил бүрэн хэрэгжиж дууссан.
20		Баруун-Урт - Эрдэнэцагаан - Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам	290 км	Барилгын ажил эхлээгүй. Зураг төсөл боловсруулагдсан.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй байна. Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замын барилгын ажлыг 2018 оноос эхлүүлэхээр тусгагдсан. Уг авто замыг Концессоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэж төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулан 2018 онд тендер зарласан боловч хэрэгжээгүй болно. Уг чиглэлийн авто замыг Концессоор хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн 2019-2020 онд багтаан эхлүүлэх саналтай байна. Энэ ажлыг эрчимжүүлэх талаар Үндэсний хөгжлийн газраас холбогдох арга хэмжээг авах шаардлагатай байна.
21		Чойбалсан-Эрэнцав чиглэлийн хатуу хучилттай авто зам	242 км	Барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замын барилгын ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тусгагдсан. Уг чиглэлийн авто замыг 2020 оны төсөвт тусган 2020 онд багтаан эхлүүлэх саналтай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
22		Хутаг-өндөр-Тэшиг-Бага-Илэнх чиглэлийн хатуу хучилттай авто зам	135 км	Барилгын ажил эхлээгүй. Зураг төсөл боловсруулагдсан.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна. Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ай Си Ти Сайн консалтинг" ХХК боловсруулсан.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт уг чиглэлийн авто замын барилгын ажлыг 2020 оноос эхлүүлэхээр тусгагдсан. Уг чиглэлийн авто замыг 2020 оны улсын төсөвт тусган 2020 онд багтаан эхлүүлэх саналтай байна.
23		Өндөрхаан-Норивлин-Баян-Уул-Улсын хил чиглэлийн хатуу хучилттай авто зам	300 км	Барилгын ажил эхлээгүй. Зураг төсөл боловсруулагдсан.		Хэрэгжээгүй	-	0%	0%	Авто замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас авто замын барилгын ажил эхлээгүй хүлээгдэж байна. Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2017 онд "Эм Си Пи Си" ХХК боловсруулсан.	Уг чиглэлийн авто замын хөрөнгө оруулалт нь шийдвэрлэгдээгүйгээс барилгын ажил нь эхлээгүй. ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй тул 2020 оноос өмнө зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Уг чиглэлийн авто замыг МУЗГ-ын 2020-2024 оны ҮАХ-т тусган хэрэгжүүлэх саналтай байна

Нийслэлийн авто зам

1	Улаанбаатар хотын авто замын 1, 2, 3 дугаар тойрог замыг шинээр бий болгох, тойрог замыг холбосон туслах зам, хотын алслагдсан дүүрэг, шинээр баригдсан орон сууцны цогцолбор хорооллуудыг холбосон авто зам барих,	Шинээр барих авто замын барилгын ажил	212 км	138.77	Улаанбаатар хотын авто замын сүлжээний хүртээмж, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, Замын хөдөлгөөний менежментийг боловсронгуй болгох, нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих.	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 оны хөгжлийн чиг хандлага, МУЗГ-ын 2016-2020 оны ҮАХ, НЗД-ын 2016-2020 ҮАХ, зэрэг баримт бичигт тусгуулан хэрэгжүүлж байгаа болно.	145 202.40	65.40%	70%	Улаанбаатар хотын төлөвлөлт, дэд бүтэц, газар зохион байгуулалтын ажлын уялдаа холбоо муу байгаа нь төсөл арга хэмжээг удаашралтай явахад нөлөөлсөн.	Улаанбаатар хотын хэмжээнд 2011-2019 оны хугацаанд нийт 138.77 км авто замыг шинээр барьж байнгын ашиглалтад оруулсан байна. Хэдийгээр зорилтод хөтөлбөрийн хүрээнд үзэхэд 65.5 хувь биелэлтэй боловч өнөөгийн хот төлөвлөлт, дэд бүтэц, газар зохион байгуулалтын ажлын уялдаа холбоогүй байгаа энэ нөхцөлд бол өндөр үр дүнтэй хэрэгжиж байгаа гэж дүгнэж байна. Санал: УБ хотын замын сүлжээг хөгжүүлэхэд Улс, Нийслэлийн төсөвт тогтвортой хөрөнгө оруулалтыг бий болгох шаардлага харагдаж байна. Тус асуудлыг бий болгосноор замын сүлжээний төлөвлөлтийг үр ашигтай төлөвлөж, газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд түлхэц болно.
2	шинэчлэн сайжруулах, Хөшигийн хөндийн нисэх буудалтай холбосон шинээр нийт 212 км авто зам, шинэчилсэн 350 км авто зам, 2 түвшний 7 гүүрэн гарц барих.	Хатуу хучилттай авто замын шинэчлэлтийн ажил	350 км	227.27			296 054.9	64.90%	70%	-	Нийслэл хотын хэмжээнд суурь түвшин 733.5 км авто замтай байсан. 2019 оны байдлаар Улаанбаатар хотын авто замын сүлжээний нийт урт 872.3 км болсон байна. Суурь түвшинтэй харьцуулахад 30.98 %-ийг шинэчилсэн байна. Замын сангийн хөрөнгийн хэмжээнд харьцуулбал өндөр үзүүлэлттэй гэж дүгнэж байна.
3		Гүүрэн гарц барих ажил	7 цэгт	Замын Цагдаагийн Газрын ойролцоох гүүрэн гарц барих ажлыг үргэлжлүүлнэ. Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах ажлыг үргэлжлүүлнэ.			42.38 сая ам.доллар	43.00%	70%	Нийт 7 гүүрэн гарц барих төсөл, арга хэмжээнээс 2 арга хэмжээг БНХАУ-ын хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Бусад арга хэмжээнүүдийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхойгүй байна.	-
							30.26 сая ам.доллар	90%			-

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хурдны зам											
1	Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны замыг барьж ашиглалтад оруулах.	Алтанбулаг - Улаанбаатар - Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам	990 км	Концессийн гэрээ хүчин төгөлдөр болж, зам барилгын ажил эхлээгүй.		Хэрэгжээгүй	-	0	0%	Алтанбулаг - Улаанбаатар - Замын-Үүд чиглэлийн хурдны замын барилгын ажлыг Концессийн зүйлийн жагсаалтад тусгасны дагуу сонгон шалгаруулалтыг Үндэсний хөгжлийн газар хариуцан зохион байгуулна. Гэрээ хүчин төгөлдөр болоогүй, барилгын ажил эхлээгүй байна.	-
Хяналт-шинжилгээ, үнэлгээний дундаж дүн										41.9%	
Хоёр. Авто тээврийн салбар											
1	Нийтийн тээврийн том оврын 800, бага оврын 1500 автобусыг шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэх	Нийтийн тээврийн бүх такси болон цагдаагийн газар, түргэн тусламжийн төвийн авто тээврийн хэрэгслүүдийг хийн түлшинд шилжүүлэх	--	--	Агаарын бохирдлыг бууруулна.	--	--	--	0%	Улсын төсөв болон "Цэвэр агаарын сан"-гийн хөрөнгөөр нийтийн тээврийн бүх такси болон цагдаагийн газар, түргэн тусламжийн төвийн авто тээврийн хэрэгслүүдийг хийн түлшинд шилжүүлэх талаар ажил хийгдээгүй болно.	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гарсан холбогдох тогтоол шийдвэрийн хүрээнд хийн түлшээр ажиллах зориулалтын авто тээврийн хэрэгсэл ашиглах шаардлагатай байна.
2		Нийтийн тээврийн дизель хөдөлгүүрт автобусанд шингэрүүлсэн нефтийн төхөөрөмж суурилуулах	400	250	Агаарын бохирдлыг бууруулна.	Бүрэн хэрэгжиж дуусаагүй.	Монгол Улсын Засгийн газрын тусгай сан "Цэвэр агаарын сан"-гийн 3.3 тэрбум төгрөг	65%	70%	1. "Цахилгаан тээвэр" ОНӨААТҮГ-ын хашаанд зөөврийн нэг станцыг барьж дууссан боловч ажиллах нөхцөл бүрдээгүй, Автобус-1" ОНӨААТҮГ, "Автобус-3" ОНӨААТҮГ-ын хашаанд хийн түлшээр цэнэглэх суурин станц барих газар байхгүй учраас баригдаагүй. 2. Нийслэлийн тээврийн газарт 2013 оны 07 дугаар сарын 10-ны өдөр БНСУ-ын "Daewoo Bus Corporation"-аас эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн зориулалтыг өөрчлөн "DAEWOO BS106" маркийн автобусанд шингэрүүлсэн шатдаг хийн нэмэлт төхөөрөмж суурилуулах нь боломжгүй талаар албан мэдэгдэл ирүүлсэн тул 7 аж ахуйн нэгж, байгууллагын 150 их багтаамжийн автобусанд	Нийтийн тээврийн их багтаамжийн 150 автобусанд уг төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниар суурилуулан гэрээг дүгнэж, 2019 оны 09 дүгээр 30-ны дотор биелэлтийг гаргаж ирүүлэх талаар Үндэсний аудитын газраас тус яаманд ирүүлсэн 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/264 ГАГ-2018-13-ГА дугаартай албан шаардлагын дагуу Нийслэлийн тээврийн газар, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох шийдвэрийг гаргуулах

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
2					--					уг төхөөрөмжийг суурилуулах ажил зогссон. 3. Автобусны насжилт, техник ашиглалтын байдал болон аюулгүй ажиллагааны баталгааны асуудал тодорхойгүй.	
3		Замын хөдөлгөөнд оролцож буй 10.0 мянга хүртэлх автотээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийн тоног төхөөрөмжийг суурилуулах	--	--		--	--	--	0%	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны захиалгаар /хуучин нэрээр/ 2013 онд "Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтын хэмжээг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах" тендер зарлаж, "Хаш техник" ХХК шалгарч, автотээврийн хэрэгслээс ялгарах хорт утаа болон тортогжилтын хэмжээг 30-60% хувиар бууруулах "SNP-800" нэмэлт төхөөрөмжийг 2013 онд 1700 гаруй автотээврийн хэрэгсэлд суурилуулсан.	--
4	Тусгай замын автобусны үйлчилгээг Улаанбаатар хотын гол гудамж замд нэвтрүүлсэн ээр цагийн нарийн хуваарь бүхий их багтаамжийн автобусаар зорчигчдыг тав тухтай, аюулгүй, түргэн шуурхай зорчих нөхцөлийг бүрдүүлэн, хувийн тээврийн хэрэгслийн хэрэглээг бууруулах, түгжрэл багасгах, агаарын бохирдлыг бууруулах.	Тусгай замын автобусны үйлчилгээ, их багтаамжийн нийтийн тээврийн бусад төрлийг нэвтрүүлэх боломжийг судлах	--	--	1. 44.9 км авто замыг өргөтгөн сайжруулна. 2. Автобусны зогсоол 60-ийг шинээр барина. 3. Тусгай замын автобусны систем – 1 шугам 44.9 км-ийг шинээр барина. 4. Нийтийн тээврийн хэрэгсэл (Тусгай замын автобус) 145-ыг шинээр авна.	Төслийн 1 дүгээр үеийн ажлын хүрээнд Тусгай замын автобусны сүлжээний гурван коридорын нарийвчилсан зураг төсөл боловсруулах, 1 коридорын барилгын ажлын хяналт гүйцэтгэх зөвлөх үйлчилгээг 2017 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зарлаж, сонгон шалгаруулалт үргэлжилсээр 2018 оны 8 дугаар сард гэрээний хэлэлцээр амжилтгүй болж дахин зарлахаар шийдвэрлэсэн.	--	--	0%	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжүүлж буй "Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр /BRT/-ын төслийн хүрээнд нийтийн тээврийн салбарт шинэ систем нэвтрүүлэх ажлын хүрээнд дэд бүтцийг 3-н үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	--

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
5	Эхний ээлжинд 50дуобус үйлдвэрлэх ийн зэрэгцээ дизель хөдөлгүүртэй хуучин 100 автобусыг цахилгаан хөдөлгүүртэй болгох	JEА-800Fмаркийн дуобус үйлдвэрлэж угсрах	50	29 Дуобус	1 937 605 000 төгрөг	--	--	--	0%	Зам, тээвэр барилга, хот байгуулалтын яам, "Цахилгаан тээвэр" ОНӨААТҮГ-тай /хуучнаар/ байгуулсан "Цахилгаан тээврийн хэрэгсэл 12 ширхэг Дуобус угсрах" ЦТХ-ДУ 2011/01/72 дугаартай гэрээний дагуу уг аж ахуй нэгж нь нийт 1 937 605 000.00 / нэг тэрбум есөн зуун гучин долоон сая зургаан зуун таван мянга/ төгрөгөөр 12 ширхэг доубусыг 2012 оны 12 дугаар сарын 20-ны дотор угсарч Захиалагчид нийлүүлэх байсан бөгөөд 10-ийг угсарч нийтийн тээврийн үйлчилгээнд гаргасан бөгөөд 2 доубусыг санхүүжилт дутсан шалтгаанаар нийлүүлээгүй байна.	Гэрээнд заасан тоо хэмжээгээр нийлүүлээгүй тул тус яамнаас шүүхэд нэхэмжлэл гаргаж, "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ -тай иргэний хэрэг үүсгэн, шийдвэрлэх шатанд явж байна.
6		Дизель хөдөлгүүрт автобусыг хийн түлшинд шилжүүлэх	--	--	--	--	--	--	0%	Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн хэрэгслийг байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрт шилжүүлж, авто тээврийн хэрэгслээс ялгарах утааг бууруулах цогц арга хэмжээ авах, үндсэн чиглэлийн хүрээнд нийтийн тээврийн том оврын 400 автобусыг шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэхээс их багтаамжийн 250 автобусанд дизель-хийн нэмэлт тоног төхөөрөмж суурилуулсан. Нийслэлийн тээврийн газарт 2013 оны 07 дугаар сарын 10-ны өдөр БНСУ-ын "Daewoo Bus Corporation"-аас эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн зориулалтыг өөрчлөн DAEWOO BS106 маркийн автобусанд шингэрүүлсэн шатдаг хийн нэмэлт төхөөрөмж суурилуулах нь боломжгүй талаар албан мэдэгдэл ирүүлсэн тул 7 аж ахуйн нэгж, байгууллагын 150 их багтаамжийн автобусанд уг төхөөрөмжийг суурилуулах ажил зогссон.	=
Хяналт-шинжилгээ, үнэлгээний дундаж дүн										11.7%	